## БАТЛАВ

| ЗАХИАЛАГЧ: | НИЙЛҮҮЛЭГЧ: |
|---|---|
| ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ | МОНОСФАРМ ТРЕЙД ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ |
| .......... Н.ЭРДЭНЭБАЯР | Д.ЦЭРЭНБАТ .............. |
| .............. | .................................................. |
| ................................ | |

**Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төв"-д оношлуур нийлүүлэх гэрээ.**

Дугаар № 2016 он 01

Улаанбаатар хот

Нэг талаас ***Цус сэлбэлт судлалын үндэсний төв*** (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас **Монософарм Трейд** ***ХХК*** (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2015 оны 03 сарын 10-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

1.2 Захиалагч нь Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төв"-д оношлуур нийлүүлэх №2016/01 дугаартай тендерийн **"Иммуногематологийн хуруу шилний аргын 12-р багцын оношлууруудыг** нийт **5,836,000** (таван сая найман зуун гучин зургаан мянган) төгрөгөөр нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

1.3 Захиалагч нь барааны нийлүүлэлтийг нийт **5,836,000** төгрөгийн төвлөрсөн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

1.4 Нийлүүлэгч нь бараag 2016 оны 03 дугаар сарын 1-нээс 2016 оны 4 дүгээр сарын 01-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

1.5 Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

1.5.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

1.5.2 Бусад шаардлагатай баримт бичиг[1];
1.5.3 Тендер ба үнийн хуваарь;
1.5.4 Гэрээний тусгай нөхцөл;
1.5.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
1.5.6 Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
1.5.7 Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

1.6 Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

1.7 Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

1.8 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг**

2.1. Захиалагч нь 1.4-т дурдсан хугацаанд нийлүүлэгдсэн барааг хүлээн авч, хүлээн авсан тухай баримт бичиг болон нийлүүлэгчийн нэхэмжлэхийг үндэслэн 20 хоногийн дотор төлбөрийг нийлүүлэгчийн данс руу шилжүүлэх үүрэгтэй.

2.2. Захиалагч нь гэрээгээр тохиролцсон төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд нэхэмжилсэн нийт үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх алдангийг хэтрүүлсэн хоног тутамд нийлүүлэгчид төлөх үүрэгтэй.

2.3. Захиалагч нь нийлүүлэгчийн нийлүүлсэн бараа техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй, эсвэл нийлүүлэгч нь гэрээний бусад үүргээ биелүүлээгүй тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь болон хэсэгчлэн цуцлах үүрэгтэй.

**Гурав. Гүйцэтгэгчийн эрх үүрэг**

---

3.1. Нийлүүлэгч нь гэрээний бүх нөхцөл, техникийн тодорхойлолтонд нийцсэн барааг нийлүүлэх үүрэгтэй.

3.2 Барааны шошго нь тендерийн материалд заасны дагуу англи хэл дээр бичигдсэн байна.

3.3. Нийлүүлэгч нь барааг шаардлагын дагуу зөв тээвэрлэн хүргэх нөхцөлийг хангах асуудлыг бүрэн хариуцана.

3.4. Нийлүүлэгч нь барааны тоо хэмжээг дутаах, нийлүүлэх хугацааг хоцроох асуудал гаргасан тохиолдолд гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээгээр хоногийн 0,1%-ийн алдангийг захиалагчид төлнө.

**Дөрөв. Хүчинтэй хугацаа**

Гэрээ нь нийлүүлэгч барааг захиалагчид хүлээлгэн өгч, төлбөрийг дансаар хүлээн авч дуусах хүртэл хүчинтэй байна.

**Тав. Бусад зүйл**

5.1. Талууд гэрээнд холбогдох асуудлаар албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

5.2. Гэрээ хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн аливаа маргааныг талууд зөвшилцлийн журмаар шийдвэрлэх ба зөвшилцөх боломжгүй болсон тохиолдолд ХАҮТ-ын дэргэдэх арбитрын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Уг гэрээ нь монгол хэл дээр 2 хувь хийгдсэн ба талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчинтэй болно.

| ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ : |
| --- | --- |
| Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төвийн ерөнхий нябо Д. Гүнжээ | Монософарм трейд ХХК менежер Ц.Амарбаясгалан |
| ........................................ | ........................................ |
| ........................................ | ........................................ |
| ........................................ | ........................................ |
| Хаяг: Сүхбаатар дүүрэг Энхтайвны өргөн чөлөө | Хаяг: Баянзүрх дүүрэг Намъяанжугийн гудамж |
| Утас: 326504 | Утас:976-11-450054, факс:463158 |
| Факс: 976-11- 312857 | |

Монгол улсын гадна үйлдвэрлэгдсэн
бөгөөд импортоор орж ирэх барааны үнийн хуваарь

огноо:2016.02.12
НТШ-ын дугаар : 2016/01

**Ховор бүлэг тодорхойлох шинжилгээний оношлуурын багц № 12**

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| № | Бүтээгдэхүүний нэр | Тун | Үйлдвэрлэсэн компани | Гарал үүслийн улс | Тоо ширхэг | СИП нийт нэгж үнэ ₮ | Нэр төрлийн нийт дүн ₮ |
| 1 | Анти Д сул (IgG) | 1*5мл | Гематолог | ОХУ | 20 | 8 000,00 | 160 000,00 |
| 2 | anti D IgG/IgM | 1*5мл | Гематолог | ОХУ | 5 | 11 000,00 | 55 000,00 |
| 3 | А слабый $A_2$ | 1*5 мл | Гематолог | ОХУ | 2 | 8 000,00 | 16 000,00 |
| 4 | бага ионы хүчтэй уусмал liss solution | 1*10 мл | Гематолог | ОХУ | 20 | 1 500,00 | 30 000,00 |
| 5 | Анти АВ | 1*10 мл | Гематолог | ОХУ | 4 | 9 000,00 | 36 000,00 |
| 6 | Анти Е | 1*5 мл | Гематолог | ОХУ | 15 | 10 000,00 | 150 000,00 |
| 7 | Анти С | 1*5 мл | Гематолог | ОХУ | 15 | 10 000,00 | 150 000,00 |
| 8 | Анти е | 1*5 мл | Гематолог | ОХУ | 15 | 16 000,00 | 240 000,00 |
| 9 | Анти с | 1*5 мл | Гематолог | ОХУ | 15 | 16 000,00 | 240 000,00 |
| 10 | Anti- A1 Lectin | 1*5 мл | Гематолог | ОХУ | 4 | 14 000,00 | 56 000,00 |
| 11 | anti- C3d coombs reagent | 1*10 мл | Гематолог | ОХУ | 10 | 8 000,00 | 80 000,00 |
| 12 | coombs serum IgG without anti c3d | 1*10 мл | Гематолог | ОХУ | 30 | 4 500,00 | 135 000,00 |
| 13 | coombs IgG -c3d | 1*10 мл | Гематолог | ОХУ | 10 | 8 000,00 | 80 000,00 |
| 14 | Анти H bombay | 1*2 мл | Lorne Lab | Англи | 2 | 130 000,00 | 260 000,00 |
| 15 | Anti M | 1*2 мл | Гематолог | ОХУ | 2 | 40 000,00 | 80 000,00 |
| 16 | Anti N | 1*2 мл | Гематолог | ОХУ | 2 | 40 000,00 | 80 000,00 |
| 17 | Anti $Kp^a$ | 1*2 мл | Lorne Lab | Англи | 2 | 130 000,00 | 260 000,00 |
| 18 | Anti $Kp^b$ | 1*2 мл | Lorne Lab | Англи | 2 | 95 000,00 | 190 000,00 |
| 19 | Anti $Lu^a$ | 1*2 мл | Lorne Lab | Англи | 2 | 275 000,00 | 550 000,00 |
| 20 | Anti $Lu^b$ | 1*2 мл | Lorne Lab | Англи | 2 | 255 000,00 | 510 000,00 |
| 21 | $Le^a$ | 1*2 мл | Lorne Lab | Англи | 2 | 62 000,00 | 124 000,00 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 22 | $Le^b$ | 1*2 мл | Lorne Lab | Англи | 2 | 62 000,00 | 124 000,00 |
| 23 | $Fy^a$ | 1*2 мл | Lorne Lab | Англи | 2 | 70 000,00 | 140 000,00 |
| 24 | Fyb | 1*2 мл | Lorne Lab | Англи | 2 | 70 000,00 | 140 000,00 |
| 25 | Jka | 1*2 мл | Lorne Lab | Англи | 2 | 65 000,00 | 130 000,00 |
| 26 | Jkb | 1*2 мл | Lorne Lab | Англи | 2 | 65 000,00 | 130 000,00 |
| 27 | $Di^a$ | 1*2 мл | Lorne Lab | Англи | 2 | 260 000,00 | 520 000,00 |
| 28 | $Di^b$ | 1*2 мл | Lorne Lab | Англи | 2 | 410 000,00 | 820 000,00 |
| 29 | Anti S | 1*2 мл | Lorne Lab | Англи | 2 | 100 000,00 | 200 000,00 |
| 30 | Anti s | 1*2 мл | Lorne Lab | Англи | 2 | 75 000,00 | 150 000,00 |
| | | | | | | | **5 836 000,00** |

## БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ Иммуногематологийн хуруу шилний аргын оношлуурын багц №15

| Код | Бүтээгдхүүний нэр | Эмийн олон улсын буюу ерөнхий нэршил | Эмийн хэлбэр | Савлалтын хэмжээ | Шаардагдаж буй хэмжээ | Нийлүүлэлтийн хуваарь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Анти Д сул (IgG) | Anti D weak | Оношлуур | 1*5мл | 20 фл | 3 сарын 1 |
| 2 | anti D IgG/IgM | anti D IgG/IgM | Оношлуур | 1*5мл | 5 фл | 3 сарын 1 |
| 3 | А слабый $A_2$ Liss solution | Anti $A_2$ | Оношлуур | 1*5 мл | 2 фл | 3 сарын 1 |
| 4 | бага ионы хүчтэй уусмал liss solution | Liss | Оношлуур | 1*10 мл | 20 фл | 3 сарын 1 |
| 5 | Анти АВ | Анти АВ | Оношлуур | 1*10 мл | 4 фл | 3 сарын 1 |
| 6 | Анти Е | Anti E | Оношлуур | 1*5 мл | 15 фл | 3 сарын 1 |
| 7 | Анти С | Anti C | Оношлуур | 1*5 мл | 15 фл | 3 сарын 1 |
| 8 | Анти е | Anti e | Оношлуур | 1*5 мл | 15 фл | 3 сарын 1 |
| 9 | Анти с | Anti c | Оношлуур | 1*5 мл | 15 фл | 3 сарын 1 |
| 10 | Anti- A1 Lectin | Anti- A1 Lectin | Оношлуур | 1*5 мл | 4 фл | 3 сарын 1 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 11 | anti- C3d coombs reagent | coombs | Оношлуур | 1*10 мл | 10 фл | 3 сарын 1 |
| 12 | coombs serum IgG without anti c3d | coombs | Оношлуур | 1*10 мл | 30 фл | 3 сарын 1 |
| 13 | coombs IgG -c3d | coombs | Оношлуур | 1*10 мл | 10 фл | 3 сарын 1 |
| 14 | Анти H bombay | Анти H bombay | Оношлуур | 1*2 мл | 2 фл | 3 сарын 1 |
| 15 | Anti M | Anti M | Оношлуур | 1*2 мл | 2 фл | 3 сарын 1 |
| 16 | Anti N | Anti N | Оношлуур | 1*2 мл | 2 фл | 3 сарын 1 |
| 17 | Anti $Kp^a$ | Anti $Kp^a$ | Оношлуур | 1*2 мл | 2 фл | 3 сарын 1 |
| 18 | Anti $Kp^b$ | Anti $Kp^b$ | Оношлуур | 1*2 мл | 2 фл | 3 сарын 1 |
| 19 | Anti $Lu^a$ | Anti $Lu^a$ | Оношлуур | 1*2 мл | 2 фл | 3 сарын 1 |
| 20 | Anti $Lu^b$ | Anti $Lu^b$ | Оношлуур | 1*2 мл | 2 фл | 3 сарын 1 |
| 21 | $Le^a$ | $Le^a$ | Оношлуур | 1*2 мл | 2 фл | 3 сарын 1 |
| 22 | $Le^b$ | $Le^b$ | Оношлуур | 1*2 мл | 2 фл | 3 сарын 1 |
| 23 | $Fy^a$ | $Fy^a$ | Оношлуур | 1*2 мл | 2 фл | 3 сарын 1 |
| 24 | Fyb | Fyb | Оношлуур | 1*2 мл | 2 фл | 3 сарын 1 |
| 25 | Jka | Jka | Оношлуур | 1*2 мл | 2 фл | 3 сарын 1 |
| 26 | Jkb | Jkb | Оношлуур | 1*2 мл | 2 фл | 3 сарын 1 |
| 27 | $Di^a$ | $Di^a$ | Оношлуур | 1*2 мл | 2 фл | 3 сарын 1 |
| 28 | $Di^b$ | $Di^b$ | | 1*2 мл | 2 фл | 3 сарын 1 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 29 | Anti S | Anti S | | 1*2 мл | 2 фл | 3 сарын 1 |
| 30 | Anti s | Anti s | | 1*2 мл | 2 фл | 3 сарын 1 |